

Dräger Alcotest 5000

Архи, согтууруулах ундааг шалгах төхөөрөмж

Dräger Alcotest 5000 төхөөрөмж бол амьсгалаас согтууруулах ундааг илрүүлдэг өндөр хурдтай, олон удаа хэмжилт хийх боломжтой мэргэжлийн багаж юм.



"Тестийн явцыг харуулах"
тэмдэг




"Согтууруулах ундаа илрээгүй"
тэмдэг



"Согтууруулах ундаа илэрсэн"
тэмдэг

Alcotest® 5000 Хошуу



Хошуу нь үлээсэн агаарыг хажуу тийш чиглүүлснээр эргэн хүний нүүр рүү үлээхгүй. Эрүүл ахуйн хувьд шинэчлэгдсэн энэхүү хошуу нь нэг шинжлүүлэгчээс нөгөө хүнд халдах халдварын эрсдэлийг бууруулсан.

Дагалдах хэрэгслүүд



Alcotest 5000 хошуу

Төхөөрөмжид 3 ширхэг дагалдана.
Үлээсэн агаар нүүр рүү буцаж үлээхгүй хажуу тийш үлээнэ;
Эрүүл ахуйн хувьд тохиромжтой.

Ашиг тус

Богино хугацаанд өндөр үр дүнтэй амьсгалаар илрүүлэгч төхөөрөмж

Alcotest 5000-ийн тусламжтайгаар та минутад 12 хүртэл хүн архи уусан үгүй эсэхийг мэдэх боломжтой. Ялангуяа цагдаа болон хувийн хэвшлийн аюулгүй байдлын мэргэжилтнүүдийн хувьд богино хугацаанд олон тооны хүмүүсийг согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгах боломжтой болж байна. Жишээлбэл, томоохон хэмжээний үйл ажиллагааны үеэр, ажлын талбай, цэнгэлдэх хүрээлэн, нийтийн тээврийн хэрэгсэлд нэвтрэх цэгүүд, нисэх онгоцны бүүдлын аюулгүй байдлын үзлэгт гэх мэт. Тестээр эерэг үр дүн гарсан тохиолдолд шаардлагатай бол цусан дахь согтууруулах ундааны хэмжээг Alcotest 6820, Alcotest 7510 согтууруулах ундааны хэмжигч төхөөрөмж ашиглан тооцоолж болно.

Эрүүл ахуйн хувьд аюулгүй хошуутай, өндөр нарийвчлалтай

Согтууруулах ундааны шинжилгээ нь шинжлүүлэгч биеэрээ төхөөрөмжид хүрэх шаардлагагүйгээр явагддаг. Төхөөрөмжийн хошуу руу зөвхөн үлээхэд хангалттай. Дизайны хувьд шинэлэг энэхүү Draeger Alcotest 5000 хошуу нь тухайн субъектийн өөрийн үлээсэн агаарыг буцааж үлээх, өмнөх шинжлүүлэгчээс аливаа эмгэг төрүүлэгч халдахаас сэргийлдэг. Хэрэглэсний дараа хошууг солиход хялбархан бөгөөд энэ нь эрүүл ахуйн хувьд баталгаатай шийдэл юм.

Энгийн үйлдэлтэй, хэрэглэхэд тохиромжтой

“OK” товчлуураар ашиглахад хялбар, Alcotest 5000 нь Draeger-ийн хамгийн сүүлийн үеийн ашиглахад хялбар батлагдсан хувилбар юм. Хоёр ширхэг нэмэлт “сүм”-тай товчлууруудыг ашигласнаар та цэсүүдийг хялбархан гүйлгэж харж болно. Тухайлбал: хамгийн сүүлийн үеийн тестийн үр дүнг үзэх, тестийн тоолуурыг дахин тохируулах, дараагийн хуваарьт тохируулагдсан огноо, цэсийг өөр хэлээр тохируулах г.м. Тест хийх зааварчилгаа нь олон улсын хэлээр ойлгоход хялбар тэмдэглэгээтэй.

Зайнаас илрүүлэх

Шалгагч, шалгуулагч нар зэргэлдээ газарт биш бол (жишээлбэл: жолооч ачааны машины кабинд сууж буй бол) Alcotest төхөөрөмжийн арын хэсэгт 1/4 стандарт оролттой уртасгагч иш холбож болно. Ингэснээр амьсгалаас согтууруулах ундааг илрүүлэх явцыг хурдасгана. Батарейгаа нэг удаа шинээр цэнэглэсэн байхад Alcotest 5000 төхөөрөмж нь 5000 гаруй удаа идэвхтэй (шинжлүүлэгч хошуу руу үлээх) болон идэвхгүй байдлаар тест хийх боломжтой.

Уламжлалаас төрсөн инноваци

65 жилийн туршлагатай Дрэйгер нь амьсгалаас согтууруулах ундааг илрүүлдэг шинжилгээгээр дэлхийн зах зээлд тэргүүлэгч юм. Олон орны цагдаа нар өдөр бүр замын хөдөлгөөнд хяналт тавихдаа Alcotest бүтээгдэхүүний цуврал төхөөрөмжүүдийг ашигладаг. Alcotest 5000 нь Герман улсад үйлдвэрлэгддэг бөгөөд чанарын хамгийн өндөр стандартад нийцдэг.

Техникийн үзүүлэлт

Draeger Alcotest*5000

Хэмжилтийн хүрээ	0-ээс 0,029мг/л Дэлгэцэн дээрх “Шалгах тэмдэг” гэсэн тэмдэг нь “Архи согтууруулах ундаа илэрсэнгүй” гэсэн утгатай ногоон лед гэрлээр мэдээлэгдэнэ. 0,030мг/л -ээс Дэлгэцэн дээрх “Х” гэсэн тэмдэг нь “Архи согтууруулах ундаа илэрсэн” гэсэн утгатай, улаан лед гэрлээр илэрнэ. 2,5мг/л – ээс дээш бол Хэмжих хүрээ хэтэрсэн байна (↑↑↑)
Дээж авах стандарт	Хэмжилт нь үлээхэд урьдчилан тогтоосон хамгийн бага хэмжээнд хүрэхэд автоматаар эхэлдэг
Эхлэх цаг	Төхөөрөмжийг асааснаас 4 сек дараа ашиглаж болно
Туршилтын үр дүнг харуулах	Ойролцоогоор 2 сек дараа (0-0,029мг/л бол) Ойролцоогоор 6 сек дараа (0,5мг/л бол, өрөөний хэмд)
Хэмжилтийн үндэс	Электрохимийн Дрэгэр мэдрэгч
Дэлгэц	Арын гэрэлтэй график LCD дэлгэц 32x22мм (128 x 64 пиксель)
Лед	2 өнгийн гэрлээр хэмжилтийн үр дүнг, анхааруулах мессежийг дэлгэцэд мэдээлнэ
Дуут дохио	Дэлгэц болон анхааруулах мессежний олон янзын дохионы дуутай
Санах ой	Сүүлийн 500 үр дүнг шалгалтын дугаар, огноо, цагтай нь хадгална
Эрчим хүчний хангамж	Дэлгэцэд цэнэгийн байдлыг харуулна; 3х AA батарейгаар ажиллана, 5000 гаруй хэмжилт хийх боломжтой
Хошууны хэрэглээ	Хошуунд зориулагдсан адаптер дээр дарна
Хошуу	Ариун цэврийн шаардлага хангасан, үлээсэн агаарыг гадагшлуулах зориулалттай агааржуулалтын төхөөрөмжтэй
Үйлдлийн загвар	Туршилтын функцийг ОК товчлуураар эхлүүлнэ; Хоёр суман товчлуурыг цэсийг удирдахад ашигладаг
Тохируулга	Alcotest 5000 тохируулгын адаптерыг ашиглан шингэн болон хуурай хийгээр тохируулга хийнэ
Гадна байдал	Гаднын нөлөөлөлд тэсвэртэй поликарбонат/ термопластик полимер
Хэмжээ, жин	Хошуу батарей оролцуулаад ойролцоогоор 63 x 219 x 41 мм; ойролцоо. 245 гр.
Чичиргээ ба нөлөөллийн эсэргүүцэл	EN 60068-2-27, EN 60068-2-6, EN 60068-2-64
Европын стандартад нийцсэн тэмдэглэгээ	Цахилгаан соронзон нийцтэй байдлын заавар

Стандарт

Одоогоор ямар ч стандартад хамааралгүй байна

Дотоод цаг

Үйлчилгээний хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө анхааруулга өгнө

Үйлчилгээний давтамж

24 сар

Үйлдлийн температур

-15°C аас +50°C

Агаарын чийгшил

10-100% харьцангуй чийгшил (хураангуйлаагүй, ашиглалтанд)

Орчны даралт

600-1300 гПа

Холбоо барих :

Монгол дахь албан ёсны төлөөлөгч
Пи Эс Си ХХК

Утас : 7575 4584

И-мэйл: sales@psc-mongolia.com

